



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



Аймгийн хөдөө аж ахуйн салбарын танилцуулга



ОРХОН АЙМАГ
2018 он

АГУУЛГА

1. Оршил

2. I-р бүлэг: Малтай өрх, малчдын тоо, тэдний соёл ахуйн үзүүлэлтүүд

- Малтай өрх, малчдын тоо, малчин өрхийн тооны өөрчлөлт
- Малчдын насны бүрэлдэхүүн
- Малчдын соёл ахуйн үзүүлэлтүүд

II-р бүлэг: Малын тоо, бүтэц

- Малын тоо
- Иргэдийн хувийн малын тоо
- Хээлтэгч мал
- Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироо
- Төл бойжилт
- Том малын зүй бус хорогдол
- Хүнсний хэрэглээ

III-р бүлэг: Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж

- Бэлчээрийн хүрэлцээ
- Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж

IV-р бүлэг: Тэжээвэр амьтад

V-р бүлэг: Газар тариалангийн үйлдвэрлэл

- Тариалалт
- Ургац хураалт

3. Нэр томъёоны тайлбар

4. Дүгнэлт

5. Судалгааны хамрах хүрээ

6. Мэдээллийн эх үүсвэр

ОРШИЛ

Судалгааны зорилго:

Аймгийн эдийн засагт хөдөө аж ахуйн салбарын эзлэх байр суурь, цаашдын хандлагыг тодорхойлоход судалгааны зорилго оршино.

Судалгааны агуулга:

Судалгааг хөдөө аж ахуйн 2 дэд салбараар хийж, дэд салбар бүрт өнөөгийн байдлыг судалж, өсөлт өөрчлөлт, хувь хэмжээг тодорхойлохыг зорив.

Энэ зорилгоор мал аж ахуйн салбарын хувьд малын тооны өсөлт өөрчлөлт, бүтэц, малын төллөлт, үржлийн байдал, зүй бус хорогдол, сувайралт, хээл хаялт, бэлчээрийн даац хүрэлцээ, тэжээвэр амьтад, хээлтэгч, хээлтүүлэгч, түүний тохироо болон малтай өрх, малчдын нийгмийн байдал, малын тооны өсөлт бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүдийг тодорхойлох, газар тариалангийн салбарын хувьд тариалалт, ургац хураалт, 1га-ийн ургацыг өмнөх онтой харьцуулан судалж, гадны аймагт тариалсан талбай болон ургацын хэмжээг тооцож, аймгийн дүнд эзлэх хувь хэмжээг тогтоов.

I БҮЛЭГ: МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Малтай өрх, малчдын тоо, малчин өрхийн тооны өөрчлөлт

2017 онд 1217 малтай өрх, үүнээс 881 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж, үүнд 1396 малчид ажиллаж байна. Малтай өрх өмнөх оноос 87-оор, малчин өрхийн тоо 70-аар өсч, малчдын тоо 100-аар буурчээ.

Хүснэгт 1. Өрх, малчдын тоо, насны бүтэц

	Хэмжих нэгж	2016	2017
Малтай өрх	тоо	1130	1217
Үүнээс: малчин өрх	тоо	811	881
Малчдын тоо	тоо	1496	1396
16-34 насны	хүн	288	269
35 ба 60 нас хүртэл	хүн	940	922
Тэтгэвэрийн насны	хүн	268	205
Нийт малчдаас эмэгтэй	хүн	710	607
Насны бүтэц %	%	100.0	100.0
Үүнээс: 16-34 насны	%	19.3	19.3
35 ба 60 нас хүртэл	%	62.8	66.0
Тэтгэвэрийн насны	%	17.9	14.7
Нэг малчин өрхөд ногдох малын тоо*		163	139

Зураг 1. Өрхийн тоон өөрчлөлт




Энэ графикаас харахад 2015 оноос эхлэн малтай өрх, малчин өрхийн тоо жил дараалан нэмэгдэж байгааг илтгэж байна.

Аймгийн хэмжээний нийт өрхийн 4.2 хувь нь малтай өрх бөгөөд энэ нь 2016 оноос 0.2 пунктээр нэмэгджээ.

Малчдын насны бүрэлдэхүүн

Малчдын 43.5 хувь нь эмэгтэйчүүд ба нийт малчдын 19.3 хувь нь 16-34 насны, 66.0 хувь нь 35-60 насны, 14.7 хувь нь тэтгэврийн



насны хүмүүс байна. Өмнөх оноос нийт дүнд эзлэх 35-60 хүртэлх насны малчдын хувийн жин 3.2 пунктээр нэмэгдэж, 16-34 насныхны хувьд мөн үеийн түвшинд байж, 60 ба түүнээс дээш насныхан 3.2 пунктээр буурсан байна.


Малчдын соёл ахуйн үзүүлэлт

2017 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогоор малчин өрхийн 93.5 хувь цахилгааны эх үүсвэртэй, 85.1 хувь нь телевизортой, 34.0 хувь нь автомашинтай, 18.5 хувь нь мотоциклтой, 2.8 хувь нь трактортой байна.

Хүснэгт 2. Малчдын соёл, ахуйн үзүүлэлт

	Өрхийн тоо		Малчин өрхийн тоонд эзлэх хувь	
	2016	2017	2016	2017
Цахилгаантай	901	825	111.1	93.5
Телевизортой	848	751	104.6	85.1
Автомашинтай	335	300	41.3	34.0
Мотоцикльтой	179	163	22.1	18.5
Трактортой	36	25	4.4	2.8

Зураг 2. Малчдын соёл, ахуйн үзүүлэлт



Өмнөх оноос цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо 6.5 пунктээр, телевизортой өрхийн тоо 14.9 пунктээр, авто машинтай өрхийн тоо 7.3 пунктээр, трактортой өрхийн тоо 1.6 пунктээр, мотоциклтой өрхийн тоо 3.6 пунктээр бага байна.

II БҮЛЭГ: МАЛЫН ТОО, БҮТЭЦ


Малын тоо

Жилийн эцсийн мал тэжээвэр амьтдын тооллогоор 122.3 мянган толгой мал тоологдсон нь өмнөх оноос 8.8 хувиар бага байна. Өмнөх оноос тэмээ 1, адуу 915, үхэр 297 толгойгоор нэмэгдэж, хонь 4996, ямаа 8086 толгойгоор багасчээ.

Хүснэгт 3. Малын тоо, толгой

	2016	2017	2017/2016
			Хувь
Тэмээ	38	39	102.6
Адуу	11335	12250	108.1
Үхэр	21603	21900	101.4
Хонь	52652	47656	90.5
Ямаа	48576	40490	83.4
Дүн	134204	122335	91.2

Зураг 3. Малын тоо, төрөл, бүтцээр



Нийт малын 0.03 хувь нь тэмээ, 10.0 хувь нь адуу, 17.9 хувь нь үхэр, 33.1 хувь нь ямаа, 39.0 хувь хонь байна.

Иргэдийн хувийн малын тоо


122.3 мянган толгой малын 95.7 хувь нь иргэдийн хувийн, бусад нь албан газрын мал ажээ.

Хүснэгт 4. Хувийн малтай өрх, малын тоо

	Малтай өрхийн тоо	Бүгд	Үүнээс				
			тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
2016	1130	128973	36	10996	21001	49486	47454
2017	1217	117077	37	11908	21473	44239	39420

2017 онд иргэдийн хувийн малын тоо 117.1 мянган толгойд хүрч, нийт мал сүргийн 95.7 хувийг эзэлж байна. Дунджаар малтай нэг өрхөд 100 толгой мал ногдож байгаа нь өмнөх оноос 19 толгойгоор бага байна.


Зураг 4. Хувийн малын тоо, мянган толгой



Иргэдийн малын тоо толгой өмнөх оноос 9.2 хувиар буюу 11.9 мянган толгойгоор буурсанаас хонь 10.6 хувиар буюу 5.2 толгойгоор, ямаа 16.9 хувиар буюу 8.0 мянган толгойгоор буурчээ.

Иргэдийн малыг бүлэглэвэл 101-200 толгой малтай нэг өрхөд дунджаар 141, 201-500 малтай нэг өрхөд 314, 501-999 малтай нэг өрхөд 640 толгой мал ногдож байна. Мянгаас дээш толгой малтай 2 өрх байна.

Зураг 5. 2017 оны малтай өрх / малын тооны бүлгээр/



Малтай өрхийн 24.0 хувийг 10 хүртэлх толгой малтай өрх, 22.3 хувийг 11-30 толгой малтай өрх, 14.5 хувийг 51-100 толгой малтай өрх эзэлж байгаа нь бусдаасаа өндөр байна. 2016 оноос 501-999 толгой малтай өрхийн малын тоо 9.1

мянгаар, 1000-1499 толгой малтай өрхийн малын тоо 3.5 мянгаар, 201-500 малтай өрхийн малын тоо 2.5 мянгаар, 11-30 малтай өрхийн малын тоо 13 толгойгоор буурч, 51-100 толгой малтай өрхийн малын тоо 2.0 мянгаар, 10 хүртэл малтай өрхийн малын тоо 275 толгойгоор, 101-200 толгой малтай малын өрх 63 толгойгоор, 31-50 толгой малтай өрхийн малын тоо 892 толгойгоор өссөн байна.

Хээлтэгч мал

2017 онд 56.7 мянган хээлтэгч мал тоологдсон нь өмнөх оныхоос 6.4 хувиар буюу 3.9 мянган толгойгоор буурсаны дотор ингэ 50.0 хувь буюу 7 толгойгоор, эм хонь 8.4 хувиар буюу 2.1 мянган толгойгоор, эм ямаа 11.6 хувиар буюу 2.6 мянган толгойгоор буурчээ.

Хүснэгт 5. Хээлтэгч малын тоо, толгой

	2016	2017
ДҮН	60631	56734
Ингэ	14	7
Гүү	3720	4301
Үнээ	9238	9501
Эм хонь	24886	22790
Эм ямаа	22773	20135

Нийт малын 46.4 хувь нь хээлтэгч мал байгаагийн 0.01 хувь нь ингэ, 3.5 хувь нь гүү, 7.8 хувь нь үнээ, 16.5 хувь нь эм ямаа, 18.6 хувь нь эм хонь байна.

Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироо

2017 онд 1264 хээлтүүлэгч мал тоологдож, 2016 оныхоос 2.8 хувиар буюу 36 толгойгоор бага байна. 2016 оноос буур 1, азарга 41, бух 20 толгойгоор нэмэгдэж, хуц 50, ухна 48 толгойгоор буурчээ.

Хүснэгт 6. Хээлтүүлэгч малын тоо, толгой

	2016	2017
ДҮН	1300	1264
Буур	1	2
Азарга	418	459
Бух	237	257
Хуц	344	294
Ухна	300	252

Нийт хээлтүүлэгч малын 0.2 хувийг буур, 36.3 хувийг азарга, 20.3 хувийг бух, 19.9 хувийг ухна, 23.3 хувийг хуц эзэлж байна.

Хүснэгт 7. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

	Үржлийн норм	2016	2017
Ингэ	8-10	14	4
Гүү	12-15	9	9
Үнээ	35-45	39	37
Эм хонь	25-30	72	78
Эм ямаа	25-30	76	80

Хуц, ухны үржлийн норм 2.6 дахин өндөр байхад, буур, азарганы хувьд дунджаас 1.7-2.5 дахин доогуур, бухны хувьд үржлийн нормын хэмжээнд байна.

Төл бойжилт

2017 онд гарсан төлийн 99.6 хувийг буюу 45.0 мянган толгой төл бойжуулжээ.

Хүснэгт 7.: Төл бойжилт, төрлөөр, толгой


	2016	2017					
		Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Гарсан төл	45066	52185	11	2395	7964	22319	19496
Бойжсон төл	44890	49963	11	2346	7795	21173	18638
Бойжилтын хувь	99.6	95.7	100.0	98.0	97.9	94.9	95.6

Бойжуулсан төлийн тоо 2016 оноос 5.1 мянган толгойгоор их, төл бойжилтын хувь 3.9 пунктээр бага байна. Гарсан ботго 100.0 хувь, унага 98.0 хувь, тугал 97.9 хувь, хурга 94.9 хувь, ишиг 95.6 хувиар бойжжээ.

Хүснэгт 8. 100 эхээс бойжуулсан төл, төрлөөр, толгой

	2016	2017
Ботго	43	79
Унага	77	63
Тугал	81	84
Хурга	81	85
Ишиг	81	82
Аймгийн дүн	81	82

Зураг 8. 100 эхээс бойжуулсан төл, толгой



2017 онд аймгийн дунджаар 100 эхээс 82 төл бойжуулсан нь өмнөх оныхоос 1 төлөөр их байна. Үүнээс ботго 36, тугал 3, хурга 4, ишиг 1 төлөөр их, унага 14 төлөөр бага бойжуулжээ.

Том малын зүй бус хорогдол


Оны эхний малын 96.0 хувь нь онд орж, мал онд оролт өмнөх оноос 3.6 пунктээр бага байна.

Хүснэгт 9. Том малын зүй бус хорогдол, төрлөөр, толгой


	2016		2017	
	Хорогдсон малын тоо	Оны эхний малд эзлэх хувь	Хорогдсон малын тоо	Оны эхний малд эзлэх хувь
Бүгд	528	0.4	5396	4.0
Тэмээ	-	-	-	-
Адуу	79	0.9	287	2.5
Үхэр	148	0.8	807	3.7
Хонь	182	0.4	2558	4.9
Ямаа	119	0.3	1744	3.6

5396 толгой том мал зүй бусаар хорогдож, өмнөх оноос хорогдол 10.2 дахин нэмэгджээ.

Зураг 9. Том малын зүй бус хорогдол, толгой



Зураг 10. Оны эхний малд эзлэх хувь



Нийт хорогдсон малын ихэнх нь буюу 79.7 хувь нь бог мал, үүнээс хонины хорогдол хамгийн их хувийн жинг эзэлж байна.

Хүнсний хэрэглээ

2017 онд оны эхний нийт малын 9.3 хувьтай тэнцэх 11.4 мянган толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. Малын хэрэглээний зарлага өмнөх оноос 27.0 хувиар буюу 2.4 мянган толгойгоор их байна.

Хүснэгт 10. Хүнсний хэрэглээ

	2016	2017
Бүгд	8980	11406
Тэмээ	0	3
Адуу	253	394
Үхэр	1279	1856
Хонь	3620	4769
Ямаа	3828	4384

Нийт хэрэглэсэн малын 0.03 хувь нь тэмээ, 3.5 хувь нь адуу, 16.3 хувь нь үхэр, 38.4 хувь нь ямаа, 41.8 хувь нь хонь байна.

III БҮЛЭГ: МАЛЫН БЭЛЧЭЭР, ТЭЖЭЭЛИЙН ХҮРЭЛЦЭЭ ХАНГАМЖ

Бэлчээрийн хүрэлцээ:

Хонин толгойд шилжүүлснээр малын тоо 301.4 мянга болж, өмнөх оноос 1.3 хувиар буурсан байна. 100 га хадлан бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо 733 байгаа нь 2016 оноос 10 толгойгоор бага байна.

Хүснэгт 11. Бэлчээрийн хүрэлцээ хангамж

	2016	2017
Хадлан бэлчээрийн талбай /мянга га/	41.1	41.1
Нийт малыг хонин толгойд шилжүүлсэн малын тоо	305524	301442
100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо	743	733

Малын тэжээл үйлдвэрлэлт, хангамж

Энэ онд 7.2 мянган тонн өвс, тэжээлийн нэгжид шилжүүлснээр 3464.6 тн тэжээл бэлтгэсэн нь өмнөх оноос 20.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 12. Бэлтгэсэн тэжээл нэр төрлөөр, тонн


	2016	2017
Хадлан өвс	9197.8	7219.9
Таримал тэжээл	220.8	296.0
Даршны ургамал	19.1	67.1
Гар тэжээл, хужир шүү	94.0	38.8
Үр тарианы хаягдал	0.0	18.0
Сүрэл	100.0	161.0
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд (тэж.нэгж шилжүүлсэн)	4340.1	3464.6

Хүснэгт 13. Тэжээл хангамж

	2016	2017
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд (тэж.нэгж шилжүүлсэн)	4340.1	3464.6
Нийт малыг хонин толгойд шилжүүлсэн /Мянган тол/	305.5	301.4
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл, тэж.нэгж, кг	14.2	11.5

2017 онд хонин толгойд шилжүүлсэн нэг малд 11.5 кг тэжээл ногдож байгаа нь 2016 оныхоос 2.7 кг-аар багасчээ.

Зураг 11. Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл, нэгж, кг



IV БҮЛЭГ: ТЭЖЭЭВЭР АМЬТАД

Аймгийн хэмжээнд 524 гахай, 1372 шувуу, 11 туулай, 1 илжиг, 336 бүл зөгий тоологдож, өмнөх оноос гахай 17.0 хувиар, зөгий 23 бүлээр буюу 7.3 хувиар өсч, шувуу 11.8 хувиар багассан байна.

Хүснэгт 15. Тэжээвэр амьтдын тоо

	Тэжээвэр амьтдын тоо	
	2016	2017
Гахай	448	524
Шувуу	1556	1372
Илжиг	1	1
Зөгий (бүл)	313	336
Туулай	3	11

V БҮЛЭГ: ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

Тариалалт

Жилийн дунджаар хөдөө аж ахуйн нийт үйлдвэрлэлтийн 40.2 хувийг газар тариалангийн салбар эзэлдэг ба газар тариалан эрхлэлтийн 50.6 хувийг гадны аймгийн нутаг дэвсгэрт явуулж байна. Өөрөөр хэлбэл 10 ААН, 54 иргэн Булган аймгийн Бугат, Хутаг-Өндөр, Хангал суманд, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд тариалалт хийснээр нийт үр тарианы 53.7 хувь, төмсний 31.6 хувь, хүнсний ногооны 17.2 хувийг гадны аймгийн нутаг дэвсгэрт тариалжээ.

Хаврын тариалалтаар 4334.0 га-д үр тариа (үүнээс 4300.0 га-д улаан буудай), 469.2 га-д төмс, 286.8 га-д хүнсний ногоо тариалжээ. Үр тарианы төлөвлөгөөт зорилт 112.9 хувь, төмс 123.5 хувь, хүнсний ногоо 82.4 хувь, малын тэжээл 135.8 хувьтай байна. Тариалалт өмнөх оны мөн үеэс 20.1 хувиар өсчээ.

Хүснэгт 16. Тариалсан талбайн хэмжээ, га

		2016	2017
Тариалалт эрхэлсэн өрхийн тоо		617	979
Нийт тариалсан талбай		4402.5	5152.1
Үүнээс:	Үр тариа	3615.6	4334.0
	Төмс	357.6	469.2
	Хүнсний ногоо	340.4	286.8
	Техникийн ургамал /рапс/	7.0	60.0
	Жимс, жимсгэнэ	2.2	2.1

Нийт тариалсан талбайн 84.1 хувь буюу 4.3 мянган га-д үр тариа, 9.1 хувь буюу 469.2 га-д төмс, 5.6 хувь буюу 286.8 га-д хүнсний ногоо, 1.2 хувь буюу 60.0 га-д техникийн ургамал, 0.04 хувь буюу 2.1 га-д жимс жимсгэнэ тариалжээ. Өмнөх оноос нийт тариалсан талбай 17.0 хувь буюу 749.6 га-аар нэмэгдсэн байна.

Ургац хураалт

Намрын ургац хураалтаар 4074.0 га-аас 6195.6 тн үр тариа, 353.4 га-аас 3005.5 тн төмс, 249.0 га-аас 2779.1 тн хүнсний ногоо хураан авчээ.

Хүснэгт 17. Хураан ургац, тонн

		2016	2017
Хураасан ургац		18653.0	9858.6
Үүнээс:	Үр тариа	10710.2	4074.0
	Төмс	3874.4	3005.5
	Хүнсний ногоо	4068.4	2779.1
	Техникийн ургамал /рапс/	0	0

Өмнөх оноос хураасан үр тариа 4.5 мян.тн буюу 42.2 хувиар, төмс 0.9 мян.тн буюу 22.4 хувиар, хүнсний ногоо 1.3 мян.тн буюу 31.7 хувиар бага байна.

Нэг га-аас дунджаар 15.2 цн үр тариа, 85.0 цн төмс, 111.6 цн хүнсний ногоо хураан авсан бөгөөд өмнөх оноос үр тариа 16.0 цн, төмс 23.2 цн, хүнсний ногоо 8.6 цн-ээр бага байна.

НЭР ТОМЪЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ:

Малтай өрх. Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх.

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амжиргааны эх үүсвэр болж байгаа өрх.

Малчид. Малчин өрхийн 16 ба түүнээс дээш насны гишүүд

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хамруулна.

Тэмээ-4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу-3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр-2 настай, 3 ба түүнээс дээш настай

Хонь -тухайн жилийн төл малаас бусад насны мал

Ямаа-тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал.

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3настай

Адуу-Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр-Өнгөрсөн жилийн төл

Төл мал. Тухайн жилд гарсан төл.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт, зарлага тал нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан 100-аар үржүүлнэ.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан, 100-гаар үржүүлнэ.

Том малын зүй бус хорогдолд. өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулага, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Нэг га: 10000 м² талбайг хэлнэ.

Нэг центнер: 100 кг - тай тэнцэнэ.

Нэг тонн: 1000 кг - тай тэнцэнэ.

ДҮГНЭЛТ

Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн үзүүлэлтээр манай аймаг улсын хэмжээнд харьцангуй бага хувийг эзэлдэг ба энэ нь газар нутаг багатайн дээр уул уурхайд түшиглэсэн хотжилт түлхүү хөгжсөнтэй холбоотой.

Мал аж ахуй

2017 оны байдлаар аймгийн хэмжээнд 881 малчин өрх, 1396 малчин мал аж ахуй эрхэлж байна. Өмнөх оноос малчин өрх, малчдын тоо нэмэгджээ.

2017 онд малчин өрхүүд 122.3 мянган толгой мал тоолуулсан нь өмнөх оныхоос 11.9 мянган толгойгоор буюу 8.8 хувиар буурчээ.

Тухайлбал: Малын төрлөөр авч үзвэл тэмээ 2.6 хувь буюу 1 толгойгоор, адуу 8.1 хувь буюу 915 толгойгоор, үхэр 1.4 хувь буюу 297 толгойгоор өсч, хонь 9.5 хувь буюу 5.0 мянган толгойгоор, ямаа 16.6 хувь буюу 8.1 мянган толгойгоор буурчээ.

Том малын зүй бус хорогдол өмнөх оноос 10.2 дахин өссөн ба нийт хорогдлын 47.4 хувь нь хонь, 32.3 хувь нь ямаа, 15.0 хувь нь үхэр, 5.3 хувь нь адуу байна.

56.7 мянган хээлтэгч мал тоологдсон нь нийт малын 46.4 хувийг эзэлж, өмнөх оноос хээлтэгчийн тоо 6.4 хувь буюу 3.9 мянган толгойгоор буурчээ.

2017 оны байдлаар 49963 төл бойжуулсан нь өмнөх оноос 11.3 хувиар буюу 5073 төлөөр, малын зүй бус хорогдол 10.2 дахин их буюу 4.9 мянган толгойгоор, хээл хаясан хээлтэгч 3.0 дахин буюу 1.3 мянган толгойгоор, сувайрсан хээлтэгч 86.7 хувиар буюу 3.5 мянган толгойгоор, 100 эхээс бойжуулсан төл нь 1.2 хувиар буюу 1 төлөөр өсч, хээлтэгч мал 6.4 хувиар буюу 3.9 мянган толгойгоор буурчээ.

Малын үржлийн нормоор үнээнээс бусад малын төрөл дээр хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо алдагдсан байна. (хүснэгт 7.) Энэ байдал жилийн жилд гардаг үзэгдэл бөгөөд энэ нь мал үржлийн ажлыг бодлогоор зохицуулж хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Мал сүргийн 72.1 гаруй хувь нь бог мал, бог малын дийлэнхи нь хонин сүрэг, бод малын дийлэнхи нь үхэр сүрэг ба аймгийн малын бүтцэд бог малын эзлэх хувийн жин өсөх хандлага жил бүр хадгалагдаж байна.

Газар тариалан

Хаврын тариалалтаар 4334.0 га-д үр тариа (үүнээс 4300.0 га-д улаан буудай), 469.2 га-д төмс, 286.8 га-д хүнсний ногоо тариалжээ. Үр тарианы төлөвлөгөөт зорилт 112.9 хувь, төмс 123.5 хувь, хүнсний ногоо 82.4 хувь, малын тэжээл 135.8 хувьтай байна. Тариалалт өмнөх оны мөн үеэс 20.1 хувиар өсчээ. Үр тарианы 53.7 хувь, төмсний 31.6 хувь, хүнсний ногооны 17.2 хувийг гадны аймгийн нутаг дэвсгэрт тариалжээ.

Намрын ургац хураалтаар 4074.0 га-аас 6195.6 тн үр тариа, 353.4 га-аас 3005.5 тн төмс, 249.0 га-аас 2779.1 тн хүнсний ногоо хураан авчээ. Хураасан талбайн 1 га-аас 15.2 цн үр тариа, 85.0 цн төмс, 111.6 цн хүнсний ногоо хураасан байна.

Нийт үр тарианы 58.9 хувь буюу 3653.6 тн, төмсний 59.1 хувь буюу 1777.7 тн, хүнсний ногооны 12.3 хувь буюу 342.1 тн-ыг гадны аймгийн нутаг дэвсгэрт тариалсан талбайгаас хураан авчээ.

Аймагт газар тариалангийн хэмжээ бага, тариалангийн талбай хүрэлцдэггүйгээс хөрш, зэргэлдээ аймгийн газар нутагт тариалалт хийдэг аж ахуйн нэгж, иргэд цөөнгүй байдаг. Жилд дунджаар 10-аад ААНБ, 50 гаруй өрх, иргэд гадны аймгийн нутаг дэвсгэрт газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг нь үүнийг нотлох ба нийт тариалалтын 50 орчим хувийг гадны аймаг, сумын нутаг дэвсгэрт явуулж байна.

СУДАЛГААНЫ ХАМРАХ ХУГАЦАА: 2016-2017 он, зарим график дүрслэлийг 5 жилээр гаргав.

МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР:

- 2016-2017 оны жилийн эцсийн мал тооллогын материал
- 2017 оны аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн статистикийн бюллетень
- 2017 оны улсын статистикийн эмхэтгэл
- Статистикийн шинжилгээ судалгаа хийх арга зүйн зөвлөмж /Аймаг, дүүргийн статистикийн хэлтсийн ажилтнуудад зориулав/